

БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН УУШГИНЫ ЦОЧМОГ
ҮРЭВСЭЛ ӨВЧНИЙ ҮЕД ХЭРЭГЛЭЖ БҮЙ ЭМИЙН ХЭРЭГЛЭЭГ СУДАЛСАН ДҮН

Г.Бямбасүрэн¹, Л.Уламбаяр²

Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль

THE STUDY OF THE DRUG USE TREATING COMMUNITY ACQUIRED
PNEUMONIA IN CHILDREN

Byambasuren.G¹, Ulambayar.L²

Mongolian University of Pharmaceutical Sciences

e-mail: byambasuren.g@monos.mn

Abstract

Respiratory diseases are the most common among the population of Mongolia, besides, the data regarding the pneumonia and chronic obstructive lung disease (COLD) among the community acquired pneumonia in children specially 0-5 year old has taken into much consideration when reviewing the statistical report of 2010-2018 of Mongolia.¹

Looking at the details, as regards 2010-2011 there were 82 CAP case, which increased by 6.8%, but in 2011-2012, 48 cases were registered, which dropped into 3.7%. Again in 2012-2013, jumped by 2.6 % by reporting 33 cases. Then from 2013 to 2014, it has become 406 cases, increased by 31.8% whereas it added up to 848 cases registered in 2014-2015, which fell by 50.4%. 788 cases reported in 2015-2016, rose by 94.7%. Then the figure decreased by 2.2%, only 36 reported cases in 2016-2017, again it soared up to 14.1% when 224 cases were registered in 2017-2018. In the last 9 years, the community acquired pneumonia among the 0 to 5 year olds in Ulaanbaatar city has increased by 10.4%.

Reviewing the Statistical Report of 2010-2018 of Mongolia, hospitalized cases of the children aged from 0-5 year old for CAP has gradually increased from 2010 to 2014; the total number of the above mentioned cases has become 8603 and the average increase was 13,1%.

In fact, the figure fell by 40% by reporting 8071 cases in 2014-2015 which whereas in 2015-2016 there were 13073 cases, an increase of 108.3%. Then, in 2016-2017, the number has decreased by 6.3% with 1604 reported cases. But in 2017-2018, registering 3260 cases, the rated jumped by 13.9%.²

In the recent 9 years, the pneumonia cases among the 0 to 5 year old children admitted to the hospitals of Ulaanbaatar city have increased by 15.7%. Therefore we have studied the actual medicine consumption in the treatment of the CAP among 0 to 5 year old.

The research data was processed by cross-sectional study by employing retrospective analysis is used to randomly select actual drug consumption from the records of the inpatients who diagnosed as CAP.

Result of the study: In the last 9 years, the CAP among the 0 to 5 year old children hospitalized in Ulaanbaatar city has increased by 15.7%.

The number of the inpatients diagnosed as the CAP has reached 21535 cases, which is increased by 6.2% in 2014-2018. Furthermore, there is tendency to increase pneumonia cases by 31509; it's possible to have approximately an increase of 5.1% in the 2019-2023.

We have revealed 30 different types of medicines have been used for the treatment of the CAP after examining prescribed drugs.

Key words: Community acquired pneumonia (children aged 0 to 5 year), drug use

Үндэслэл:

Хүн амын нягтаршил, хотжилт, орчны болон агаарын бохирдол, амьдралын буруу хэвшил нь халдварт бус өвчний эрсдэлийг нэмэгдүүлэх шалтгаан болсоор байна. Улаанбаатар хотын агаарын бохирдлын түвшин хэт өндөр байгаа нь агаар бохирдуулагч утааны ялгарал их, газар зүйн байрлал болон цаг уурын нөхцөлийн хосолмол хүчин зүйлээс үүдэлтэй юм.

Агаарын бохирдлын өртөлтөнд орж буй хамгийн эмзэг бүлэг бол хүүхдүүд юм. 2017 оны эрүүл мэндийн статистик мэдээ тайлангаар 0-5 хүртэлх насны хүүхдийн өвчлөлийн шалтгаанд амьсгалын тогтолцооны өвчин тэргүүлэх байр эзэлж байна.^{3,4}

0-5 хүртэлх насны хүүхдүүдийн дунд тохиолдох амьсгалын тогтолцооны өвчлөлөөс уушгины хатгалгаа 25.4%-ийг эзэлж байна.⁵

ДЭМБ-ын мэдээлснээр дэлхийн хүүхдийн нас баралтын гол шалтгаан уушгины хатгалгаа 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгааны 17.5%-ийг эзэлж байна.⁶

Дээрх нөхцөл байдлын улмаас **СХДНЭ, ХУДНЭ-г хэвтэн эмчлүүлсэн** 0-5 хүртэлх насны хүүхдүүдийн дунд зонхилон тохиолддог өвчнүүдийн нэг болох УЦҮӨ-ий үед хийгдэж буй эмчилгээний эмийн бодит хэрэглээг судлах шаардлага тулгарч байна.

Судалгааны зорилго, зорилт

Бага насны 0-5 хүртэлх насны хүүхдийн уушгины цочмог үрэвсэл өвчний үед хийгдэж буй эмчилгээний эмийн бодит хэрэглээг судлах. Зорилгоо биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн.

1. Амьсгалын эрхтэн тогтолцооны өвчин түүний дотор зонхилон тохиолдож буй уушгины цочмог үрэвсэл өвчний хөдлөл зүйг (0-5 нас) эрүүл мэндийн статистикийн тайлангаас судлан, өвчлөлийн прогнозыг гаргах.
2. Хүүхдийн уушгины цочмог үрэвсэл өвчний үед хэрэглэж буй эмийн бодит хэрэглээг судлан тогтоох.

Судалгааны хэрэглэгдэхүүн:

- Эрүүл мэндийн үзүүлэлтүүд 2010-2018 оны өвчлөлийн статистик мэдээ тайлан. ЭМЯ
- Уушгины үрэвслийн оношилгоо, эмчилгээний стандарт MNS 6136:2010
- ДЭМБ-ын удирдамж, стандарт
- СХДНЭ-ийн хүүхдийн тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн (0-5 насны хүүхэд) өвчний түүх
- ХУДНЭ-ийн хүүхдийн тасагт хэвтэн эмчлүүлэгчдийн (0-5 насны хүүхэд) өвчний түүх

Судалгааны арга: Нэг агшны (cross-sectional studies) загвараар хүүхдийн УЦҮӨ-ий оношоор хэвтэн эмчлэгдсэн өвчний түүхэнд ретроспектив (retrospective) судалгааны аргыг ашиглан эмийн бодит хэрэглээг тусгайлан боловсруулсан судалгааны картаар түүвэрлэсэн.

Судалгааны түүвэр:


Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн (0-5 нас) эмчлүүлэгчдийн бодит тоон мэдээн дээр үндэслэн дундаж эх олонлогийг тооцсон дүнг дараах хүснэгтээр харуулав.

Table 1

Amount compared to the statistical population

The name of the patients	The number of inpatients for a year (by year)					Statistical population
	2014	2015	2016	2017	2018	Average
Pneumonia	20138	12067	25140	23536	26796	21535.4

Дээрхэх олонлогт үндэслэн судалгааны үнэн магадлалын төлөөлөл болж чадах түүврийн хэмжээг эх олонлог дахь пропорцийг харьцангуй нарийвчлалтайгаар тооцоолох хүснэгтийг ашиглан sample size calculator-аар тооцсон дүнг дараах зургаар харуулав.⁷



Picture 1. Estimated amount of random sample

95 хувийн үнэн магадлалтайгаар 96 өвчний түүхийг сонгон авч хэвтэн эмчлүүлсэн ор хоног, өвчний төгсгөл, эмийн зардал, эмчилгээнд хэрэглэсэн эмийг түүвэрлэн авсан.

Судалгааны үр дүн: Сүүлийн 9 жилийн дунджаар Улаанбаатар хотын 0-5 хүртлэх насны хүүхдүүдийн УЦҮӨ 10.4%-иар өссөн байна.

Харин сүүлийн 9 жилийн дунджаар Улаанбаатар хотын эмнэлэгт хэвтэн

эмчлүүлсэн 0-5 хүртлэх насны хүүхдийн УЦҮӨ нь 15.7%-иар өссөн байна.

Энэхүү УЦҮӨ нь улирлын чанартай өвчлөл учраас бид судалгаанд хамрагдагсдыг сонгохдоо 12 сараас 02 сар хүртлэх хугацаан дахь өвчний түүхийг түүвэрлэсэн болно.

Бага насны хүүхдийн УЦҮӨ-өөр цаашид тухайн жилд хэвтэн эмчлэгдсэн хүүхдийн тоог (Хүснэгт 2) харуулав.

Table 2


The number of the children aged 0 to 5 year hospitalized with pediatric pneumonia

Name of patients	The number of inpatients for per year (by year)				
	2014	2015	2016	2017	2018
Pneumonia	20138	12067	25140	23536	26796

	Perspective				
	2019	2020	2021	2022	2023
	27591	31108	29959	35018	33869

Хүснэгт 2-оос үзэхэд УЦҮӨ-өөр эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн эмчлүүлэгчийн тоо 2014-2018 онд дунджаар 21535 тохиолдол ба 6.2%-иар өсч цаашид 2019-2023 онуудад дунджаар 31509 тохиолдол ба 5.1%-иар өсөх хандлагатай байна.

2010-2018 онуудад бага насны хүүхдийн УЦҮӨ-ий тохиолдлын өсөлт бууралтын хувийг дараах зургаар харуулав.



Picture 2. The fluctuation of the pediatric pneumonia cases from 2010-2018

Зураг 2-оос харахад бага насны хүүхдийн УЦҮӨ-ий тохиолдол сүүлийн 9 (2010-2018) жилд дунджаар 15.7 хувиар өссөн байна.

Судалгаанд хамрагдсан хүүхдийн насны үзүүлэлт

Судалгаанд 0-5 насны 96 хүүхэд хамрагдсаны дундаж нас 2.6 ± 0.3 жил байв. Судалгаанд хамрагдагсдыг 1 насны интервалаар 5 бүлэгт ангилан үзсэн дүнг (Хүснэгт 3) харуулав.

Table 3

Median age, the percentage of the survey participants (by age groups)

Age group	Male	Female	Total	Average age (year)	Percentage %	All participants	
				M \pm SD		Male	Female
0-1 нас	19	12	31	$0.6 \pm 0.3^*$	32.3%		
1,1-2 нас	19	14	33	$1.4 \pm 0.3^*$	34.4%		
2,1-3 нас	6	9	15	$2.5 \pm 0.3^*$	15.6%	54.2%	45.8%
3,1-4 нас	2	1	3	$3.9 \pm 0.4^*$	3.2%		
4,1-5 нас	6	8	14	$4.8 \pm 0.2^*$	14.5%		
Total	52	44	96	$2.6 \pm 0.3^*$	100%	100%	

Remark: * p<0.001


Хүснэгт 3-аас үзэхэд 0-1 насны бүлэгт 32.3% (n=31) үүний 19 нь эрэгтэй, 12 эмэгтэй, 1-2 насны бүлэгт 34.4% (n=33) үүний 19 нь эр, 14 эмэгтэй, 2-3 насны бүлэгт 15.6% (n=15) үүний 6 нь эрэгтэй, 9 нь эмэгтэй, 3-4 насны бүлэгт 3.2% (n=3) үүний 2 нь эрэгтэй, 1 нь эмэгтэй, 4-5 насны бүлэгт 14.5% (n=14) үүний 6 нь эрэгтэй, 8 нь эмэгтэй эмчлүүлэгч хамрагдсан байна.

Судалгаанд хамрагдсан нийт 96 эмчлүүлэгчийн хүйсийн байдлыг судлан үзэхэд 54.2% нь эрэгтэй хүүхэд, 45.8%-ийг эмэгтэй хүүхдүүд эзэлж, 0-2 насны хүүхэд УЦҮӨ-д илүү өртөмхий байгаа нь харагдаж байна.

Уушгины цочмог үрэвсэл өвчнөөр эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн 0-5 насны хүүхдийн эмчилгээнд хэрэглэж буй эмийн хэрэглээг судалсан дүн

2014-2018 онуудад СХДНЭ, ХУДНЭ-т уушгины цочмог үрэвсэл өвчнөөр хэвтэн эмчлүүлэгчдэд хэрэглэсэн эмийн зарцуулалтыг урьдчилан боловсруулсан судалгааны картаар эмчлүүлэгчийн өвчний түүхээс хэрэглэсэн эмийн нэр, тун хэмжээ, эм хэрэглэсэн хоног, эм нэг бүрийн үнэ, эмийн савалгааны хэлбэр зэрэг мэдээллийг түүвэрлэн авсан. Уушгины цочмог үрэвсэл өвчнөөр үндсэн онош тавигдан эмчлэгдэж буй эмчлүүлэгчдэд бичигдсэн эмийг судлан үзэхэд нийтдээ давхардсан тоогоор 30 нэр төрлийн эмийг хэрэглэж байна.

УЦҮӨ-ний оношилгоо, эмчилгээний удирдамжинд заагдсан эмчилгээний дагуу эмийг ангилан үзсэн байдлыг дараах зургаар харуулав.



Picture 3. The classification of the drug used for treatment of CAP

УЦҮӨ-ий үед давхардсан тоогоор 30 нэр төрлийн эм хэрэглэж байгаагийн 14% нь антибиотик, 11% нь дааврын бус гаралтай үрэвслийн эсрэг эм, 11% нь харшлын эсрэг эм, 11% нь дархлаа дэмжих, бодисын солилцоонд нөлөөлөх эм, 11% нь В,С,Р

бүлгийн витамин, 7% нь цэр ховхлох, шингэлэх эм, 7% нь глюкокортикостероидууд, 7% нь дисбактериозын үед хэрэглэх эм, 3% нь утлага эмчилгээ, 3% нь хордлого тайлах шингэн, 3% нь аналептик, 3% нь мөөгөнцрийн эсрэг эм, 3% нь шээс хөөх эм, 3% нь бронх

өргөсгөх эм тус тус эзэлж байна. Эндээс үзэхэд антибиотик, дааврын бус гаралтай үрэвслийн эсрэг эм, харшлын эсрэг эм, дархлаа дэмжих, бодисын солилцоонд нөлөөлөх эмүүдийг илүү хэрэглэсэн байна.

УЦҮӨ-ий үед хэрэглэж буй 30 нэр төрлийн эмийн дундаж хэрэглээ болон эм хэрэглэсэн хүний тоог эмнэлэг тус бүрээр (Хүснэгт 4) үзүүлэв.

Table 4

Average consumption of drug used in treatment of CAP and the number of the patients taken the medicine

№	Name of drugs	Units	Average value of consumption of drug	The number of patients taken the drugs		
			Average consumption	SKHD	KHUD	Бүгд
1	Цефотаксим натри 500мг	флакон	10.0±4.1	14	35	49
2	Дексаметазон 4мг/2мл	туншил	3.2±1.5	9	35	44
3	Ампициллин 500мг	флакон	9.9±4.4	16	27	43
4	Цетирицин 5мг	шахмал	6.4±4.5	-	40	40
5	Линекс	капсул	7.3±2.1	13	23	36
6	Натрийн хлорид 0.9%-100 мл	флакон	8.1±1.7	42	54	32
7	АЦЦ 100мг	уут	10.4±5.4	15	12	27
8	Гентамицин 80мг/2мл	туншил	6.0±0.5	6	20	26
9	Нобивент плюс 2.5мл	флакон	6.0±2.8	9	15	24
10	Аскорутин 300мг	шахмал	8.2±9.3	16	7	23
11	Ибупрофен 400мг	шахмал	7.4±8.1	8	10	18
12	Сальбутамол 12мл	флакон	3.0±1.0	12	5	17
13	Бромгексин 8мг	шахмал	4.0±0.3	-	15	15
14	Парацетамол 500мг	шахмал	4.0±2.8	-	13	13
15	Амоксиклав 250мг+62.5мг	флакон	5.5±4.9	9	-	9
16	Аскорбины хүчил 5%-2мл	туншил	5.2±1.8	8	-	8
17	Рингер 250мл	флакон	1.8±1.0	4	4	8
18	Кетотифен 1мг	шахмал	5.2±1.6	3	3	6
19	Хлорфенамин 4мг	шахмал	3.4±2.7	6	-	6
20	Виферон 500.000	лаа	5.6±1.9	6	-	6
21	Фуросемид 1%-1мл	туншил	3.1±1.4	-	6	6
22	Димедрол 1%-1мл	туншил	5.2±2.2	-	5	5
23	Анальгин 50%-2мл	туншил	6.5±2.5	-	4	4
24	Стопдиар 100мг	шахмал	6.0±0.1	-	2	2
25	Фунголон 50 мг	капсул	5.6±5.6	3	-	3
26	Актовегин 40мг-5мл	туншил	1.5±0.2	2	-	2
27	Витамин В6 5%-1мл	туншил	1.0±0.2	1	-	1
28	Витамин РР 1%-1мл	туншил	2.1±0.5	1	-	1
29	Преднизолон 5мг	шахмал	2.0±0.1	-	1	1
30	Фезам 400/25мг	капсул	1.0±0.2	1	-	1

Дээрх хүснэгтээс үзэхэд УЦҮӨ-ий үед хэрэглэж буй эмүүдээс дундаж утга хамгийн олон нь Цефотаксим натри 500 мг-10 флакон, Ампициллин 500 мг-9 флакон, Ибупрофен 400 мг-7 шахмал, дундаж утга хамгийн цөөн нь Гентамицин 80 мг-6 туншил, Парацетамол 500 мг-4 шахмал, Бромгексин 8 мг-4 шахмал хэрэглэсэн байв.

Харин хамгийн олон буюу 49 эмчлүүлэгч Цефотаксим натри 500 мг флаконыг, 44 эмчлүүлэгч Дексаметазон 4мг/2мл туншилыг, 43 эмчлүүлэгч Ампициллин 500 мг флаконыг тус тус хэрэглэсэн байна. Харин хамгийн цөөн эмчлүүлэгч Фезам 400/25мг-2 туншил, Витамин РР 1%-1мл-2 туншил, Преднизолон 5мг-2 шахмал зэргийг хэрэглэсэн байна. Эндээс үзэхэд УЦҮӨ-ий эсрэг эмчилгээнд Цефалоспорины бүлгийн III үеийн Цефотаксимыг илүү хэрэглэсэн байна. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн эмчилгээний хувьд хамгийн олон эмчлүүлэгчид хэрэглэсэн ба давтамж өндөртэй эмүүдэд антибиотик Цефатоксим натри, Ампициллин, наркозын бус үйлдэлтэй өвдөлт намдаах эм Ибупрофен, харшлын эсрэг эм Цетризин, антиоксидант эм Аскорбины хүчил зэрэг орж байна. Харин хамгийн цөөн эмчлүүлэгчид хэрэглэсэн эмүүд нь антибиотик Гентамицин, наркозын бус үйлдэлтэй өвдөлт намдаах эм Парацетамол,

глюкокортикоид Преднизолон зэрэг байна.

УЦҮӨ-ий үед эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн эмчилгээнд хэрэглэж буй эмийн нэр төрөл, эм хэрэглэсэн эмчлүүлэгчийн тоо, эмийн хэрэглээний хувь тооцсон дүн

Судалгаанд хамрагдсан хэвтэн эмчлүүлэгчдийн эмчилгээний эмийн нэр төрөл, хэрэглэсэн эмчлүүлэгчийн тоо, эмийн хэрэглээний хувийг эмнэлэг тус бүрээр тооцсон дүнг дараах байдлаар харуулав.

СХДНЭ, ХУДНЭ-үүдэд уушгины цочмог үрэвсэл өвчний улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн эмчилгээнд хэрэглэсэн эмийн бодит хэрэглээ, эм хэрэглэсэн эмчлүүлэгчийн тоо, эмийн хэрэглээний хувь тооцсон дүнг (Хүснэгт 5) харуулав.

Table 5

Type of the drug used for the treatment of CAP in hospitals compared with the number of inpatients and the percentage of the medicine consumption

No	Name of drugs	Single fixed dose	A day dose	Duration of the drug use /by day/	The number of inpatients taken drugs	Percentage of drug use
1	Цефотаксим натри 500мг	250мг-500мг x 3	750мг-1500мг	7	49	51.0%
2	Дексаметазон 4мг/2мл	1мл x 1	1мл	7	44	45.8%
3	Ампициллин 500мг	250мг-500мг x 3	750мг-1500мг	6	43	44.7%
4	Цетирицин 5мг	2.5мг-5мг x 2	5мг-10мг	6	40	41.6%
5	Линекс	1x 3	1-3	9	36	37.5%
6	Натрийн хлорид 0.9%-100мл	10-100мл x 3	30мл-300мл	7	32	33.3%
7	АЦЦ 100мг	100мг x 2	200мг	6	27	28.1%
8	Гентамицин 80мг/2мл	40мг-80мг x 3	120мг-240мг	6	26	27%

9	Нобивент плюс 2.5мл	0.5мл-1мл х 3	1.5мл- 3мл	7	24	25%
10	Аскорутин 300мг	150мг-300мг х 1	150мг- 300мг	6	23	23.9%
11	Ибупрофен 400мг	100мг-400мг х 3	300мг- 1200мг	6	18	18.7%
12	Сальбутамол 12мл	100мкг х 3	300мкг	6	17	17.7%
13	Бромгексин 8мг	2мг-4мг х 2	4мг-8мг	5	15	15.6%
14	Парацетамол 500мг	125мг-250мг х 2	250мг- 500мг	6	13	13.5%
15	Амоксиклав 250мг+62.5мг	250мг+62.5мг х 3	937.5мг	7	9	9.3%
16	Аскорбины хүчил 5%-2мл	1мл-2мл х 1	1мл-2мл	7	8	8.3%
17	Рингер 250мл	250мл х 1	250мл	7	8	8.3%
18	Хлорфенамин 4мг	1мг-2мг х 3	3мг-6мг	6	6	6.25%
19	Фуросемид 1%- 1мл	1мл х 1	1мл	3	6	6.25%
20	Димедрол 1%- 1мл	1мл х 1	1мл	2	5	5.2%
21	Анальгин 50%- 2мл	1мл х 1	1 мл	2	4	4.1%
22	Кетотифен 1мг	0.5мг-1мг х 1	0.5мг-1мг	6	3	3.1%
23	Фунголон 50 мг	50мг х 2	100мг	8	3	3.1%
24	Виферон 500000МЕ	500.0 х 1	500.0	4	2	2%
25	Стопдиар 100мг	100мг х 1	100мг	4	2	2%
26	Актовегин 5мл	5мл х 1	5мл	9	2	2%
27	Преднизолон 5мг	2.5мг х1	2.5мг	1	1	1%
28	Витамин В6 5%- 1мл	1мл х 1	1 мл	1	1	1%
29	Витамин РР 1%- 1мл	1мл х 1	1 мл	1	1	1%
30	Фезам 400/25мг	200мг х 2	400мг	3	1	1%

Судалгаанд хамрагдсан СХДНЭ, ХУДНЭ-т УЦҮӨ-өөр эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн эмчилгээнд хэрэглэсэн эмүүдийг судалж үзэхэд халдварын эсрэг эмчилгээний хэрэглээ 27-51%, цэр ховхлох шингэлэх эмийн хэрэглээ 15.6-28.1% байна.

Хэлцэмж

Бид энэхүү судалгаагаар уушгины цочмог үрэвсэл өвчнөөр эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн

0-5 насны хүүхдийн эмчилгээнд хэрэглэж буй эмийн хэрэглээг судлан гаргалаа.

Бидний судалгаагаар сүүлийн арван жилийн статистикийн үзүүлэлтээр амьсгалын эрхтэн тогтолцооны өвчлөл нийт өвчний дотор тэргүүлэх байрыг эзэлж 2010-2018 онд Улаанбаатар хотын 10000 хүн амд ногдох 5 хүртлэх насны хүүхдүүдэд УЦҮӨ нь жилд дунджаар 10.4%-ийн өссөн үзүүлэлттэй

байгаа бөгөөд УЦҮӨ-өөр эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн (0-5 насны хүүхэд) тоо 2014-2018 онд дунджаар 21535 тохиолдол ба 6.2%-иар өсч цаашид 2019-2023 онуудад дунджаар 31509 тохиолдол ба 5.1%-иар өсөх хандлагатай байна.

Хятад улсын Сүжоу хотын Wei Shan, Ting Shi, MD2, Kaile Chen, Jian Xue, Yin Wang, Jia Yu, Genming Zhao, Jianmei Tian, and Tao Zhang эрдэмтэн нарын ретроспектив судалгаагаар 2010 оноос 2014 он хүртэл Соховын их сургуулийн харьяа Хүүхдийн эмнэлэгт УЦҮӨ-тэй эмнэлэгт хэвтсэн 5-аас доош насны хятад хүүхдүүдийн мэдээллийг цуглуулах зорилгоор судалгаа хийсэн байна. УЦҮӨ-тэй 28.043 хүүхдээс 17501 (62.4%) нь эрэгтэй, 20.747 (74.0%) хүүхэд <24 сар, 14.887 (53.1%) хүүхэд <12 сартай байжээ. Эрэгтэй, эмэгтэй хүүхдийн насны ангилал харьцангуй ялгаатай байсан байна. ($\chi^2 = 242.6$, $P < 0.001$).⁸

Бид энэхүү судалгааг нэг агшингийн загвараар, ретроспектив судалгааны аргыг ашиглан гүйцэтгэсэн нь дээрх Хятад улсын судлаачдын арга зүйтэй дүйж байна. Мөн судалгаанд хамруулсан бага насны хүүхдийн насны хязгаар, судалгааны үр дүн дүйж байна.

ДЭМБ-ын хийсэн судалгаанаас үзэхэд 2-23 сартай нийт 24287 хүүхэд уушгины цочмог үрэвсэл өвчнөөр эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн. Судалгаанд 6 орныг хамруулсан байна. УЦҮӨ-өөр эмнэлэгт хэвтсэн хүүхдүүдийн дундаж нас судалгаанд хамрагдсан 6 улсын хувьд уушгины хатгалгааны тохиолдол нэг их ялгаагүй байна. ДЭМБ-ын судалгаагаар УЦҮӨ-ий улмаас эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн хүүхдүүдийн дундаж нас 9-12 сар байна.⁹

Америкийн нэгдсэн улсын [Ian C Michelow](#)¹, [Kurt Olsen](#), [Juanita Lozano](#), [Nancy K Rollins](#), [Lynn B Duffy](#), [Thedi Ziegler](#), [Jaana Kauppila](#), [Maija Leinonen](#), [George H McCracken Jr](#) эрдэмтэн нарын судалгаагаар уушгины цочмог үрэвсэл өвчнөөр эмнэлэгт хэвтсэн 154 хүүхэд судалгаанд

хамрагдахад 96 хүүхэд буюу 62% нь эрэгтэй хүүхэд байсан. Дундаж нас 33 сартай байсан. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн дундаж хоног 5 байсан байна.¹⁰

Бидний судалгаанд хамрагдсан 0-5 насны хүүхдийн дундаж нас 2.6 ± 0.3 жил буюу 31 сар байсан. Үүнийг ДЭМБ-ын судалгааны үр дүнтэй харьцуулахад судалгаанд хамрагдсан хүүхдийн дундаж нас 19-22 сараар илүү байна. Энэ нь ДЭМБ нь судалгаандаа 2-23 сартай нялхсыг хамруулсан байгаатай холбоотой боловч ямартай ч УЦҮӨ-өөр бага насны хүүхэд илүү өртөмхий байна гэсэн бидний судалгааны үр дүнтэй дүйж байна.

Дүгнэлт:

1. Сүүлийн 9 жилийн дунджаар Улаанбаатар хотын эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн УЦҮӨ-тэй бага насны хүүхдийн (0-5 нас) өвчлөлийн хөдлөл зүйг судлан үзэхэд жилд дунджаар 15.7%-иар өссөн үзүүлэлттэй байна. Судалгаанд 0-5 насны нийт 96 хүн хамрагдсаны дундаж нас 2.6 ± 0.3 жил байв. Өвчлөлийн прогнозыг тооцоход цаашид 2019-2023 онуудад дунджаар УЦҮӨ-д өртөх бага насны хүүхэд 31509 тохиолдол ба 5.1%-иар өсөх хандлагатай байгааг гаргалаа.
2. Судалгаанд хамрагдсан эмнэлгүүдэд бага насны (0-5) хүүхдийн УЦҮӨ-ий үед нийт давхардсан тоогоор 30 нэр төрлийн эм хэрэглэж байна. Үүний 14% нь антибиотик, 11% нь дааврын бус гаралтай үрэвслийн эсрэг эм, 11% нь харшлын эсрэг эм, 11% нь дархлаа дэмжих, бодисын солилцоонд нөлөөлөх эм, 11% нь В,С,Р бүлгийн витамин, 7% нь цэр ховхлох, шингэлэх эм, 7% нь глюкокортикостероидууд, 7% нь дисбактериозын үед хэрэглэх эм, 3% нь утлага эмчилгээ, 3% нь хордлого тайлах шингэн, 3% нь аналептик, 3%

нь мөөгөнцрийн эсрэг эм, 3% нь шээс хөөх эм, 3% нь бронх өргөсгөх эм тус тус эзэлж байгааг гаргалаа. Тус өвчлөлд ихэвчлэн антибиотик эмчилгээ хийгдсэн байна. Бага насны хүүхдийн УЦҮӨ-ий үед хийгдэж буй эмчилгээг ДЭМБ-аас гаргасан зөвлөмжтэй харьцуулахад маш хүнд хэлбэрийн үед хийгдэх эмчилгээг манайх хүндэвтэр хэлбэрийн үед хийсэн байгааг гаргалаа.

Ном зүй:

1. Эрүүл мэндийн салбарын танилцуулга. Улаанбаатар: 2019. х. 21.
2. Эрүүл мэндийн хөгжлийн төв.
3. Гуттикунда С.К, Лодойсамба С, Булгансайхан Б, Дашдондог Б. “Улаанбаатар хотын тоосонцорын бохирдол” Air Qual Atmos Heal сэтгүүл. Улаанбаатар: 2013. 6. х. 589-601
4. Гомбо Б. Навчсан Г. Хүүхдийн уушгины үрэвслийн эмнэл зүй. Анагаах ухаан, эрүүлийг хамгаалахын асуудлууд илтгэлүүдийн хураангуй. Улаанбаатар: 1986. х. 16-18.
5. <http://www.chd.mohs.mn/2018/sariin%20medee/Eruul%20mendiin%20uzuule-It-2017%20on-2018.06,25.pdf>
6. ДЭМБ, Дэлхийн эрүүл мэндийн илтгэл 2015, Мэдээллийн эх үүсвэр <http://www.who.int/gho/publications.p.103-106>
7. Дүүмаам И. Амарзаяа Ө. Эм зүйн статистик, эмийн тархвар зүй. Улаанбаатар: 2017. х. 157.
8. Нямдаваа П. Лхагва Ё. Бурмаа Б. Хүүхдийн уушги судлал. Хорьдугаар зууны монголд анагаах ухаан хөгжсөн түүхийн товчоон. Улаанбаатар: 2001. х. 28-29.
9. Дүүмаам И. Амарзаяа Ө. Эм зүйн статистик, эмийн тархвар зүй.

Улаанбаатар: 2017. х. 157.

10. Risk Factors for Severe Community-Acquired Pneumonia Among Children Hospitalized with CAP Younger Than 5 Years of Age. The Pediatric Infectious Disease Journal. 2018. p. 8-9.

Уншин танилцаж, нийтлэх санал өгсөн:
ЭЗУ-ы доктор, дэд проф И.Дүүмаам